



**ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 10 сарын 08 -ны өдөр

Лугнаар 1/104

Эрдэнэт

Г Коронавируст халдварт /ковид-19/-ын цар тахлын үеийн эмнэлгийн тусlamж үйлчилгээний зохион байгуулалтыг сайжруулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Коронавируст халдварт /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх серег нееplийг бууруулах тухай хууль, Эрүүл мэндийн Сайдын 2021 оны "Шинэ коронавируст халдар (КОВИД-19) оношилгоо, эмчилгээний тур заавар шинэчлэн батлах тухай" A/549 дүгээр тушаал, "Тур заавар шинэчлэн батлах тухай" A/456 дугаар тушаалын 6-р хавсралт "Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээнд мөрдех халдварын сэргийлэлт, хяналтын тур заавар", "Коронавируст халдварын үеийн хариу арга хэмжээний зураглал батлах тухай" A/319 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ.

1. Эрүүл мэндийн газрын дэргэд "Коронавируст халдварын цар тахлын үед эмнэлгийн тусlamж үйлчилгээг зохицуулах багийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, нарийн мэргэжлийн эмч нарын зөвлөх багийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар, багуудын ажиллах чиг үүргийг гуравдугаар, Коронавируст халдвараар евдсон иргэнийг эмнэлэг хооронд шилжүүлэх тур журмыг деревдүгээр, ӨЗМТ-дийн Тусгаарлах эмнэлэгт хэвтүүлэх хуваарийг тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Өрхийн эрүүл мэндийн төвүүд болон тусгаарлах эмнэлгүүдийн хүний неец, эм, эмнэлгийн хэрэгсэл, хамгаалах хувцас хэрэгслийн бэлэн байдлын хангаж, эмнэлгийн тусlamж үйлчилгээг тасралтгүй зохион байгуулж ажиллахыг сум, Өрхийн эрүүл мэндийн төв, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, тусгаарлах эмнэлгүүдийн дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Эрүүл мэндийн Сайдын 2021 оны A/549 дүгээр тушаалын дагуу оношилгоо, эмчилгээний зааврыг мөрдеж анх хулээж авсан эмнэлгүүд амь тэнссэн үеийн яаралтай тусlamжийг үзүүлэх, Коронавируст халдварын үеийн гарсаа эмчилгээг хийж, эмнэлэгт шилжүүлэх, хүнд өвчтөнг хэвтүүлэх 2-3 орыг неецэнд байлгаж өвчтнийг хүмдэрэх эрсдэлээс сэргийлж ажиллахыг Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн дарга (Ц.Наран-Эрдэнэ), Баян-Өндер Мед Нэгдсэн эмнэлэг (Л.Байгальмаа), Ачит эмнэлэг (Б.Цэнджав), Бадархундага эмнэлэг (С.Гүнчинсүрэн), Талын булаг (Р.Жаргал), Очир-Увидас (Н.Бүүзвэй), Тайхар эмнэлэг (Ц.Оюунцэцэг), Эрхэст Оргил (Э.Оргил) нарт үүрэг болгосугай.

4. Коронавируст халдвартай эх, хүүхдийн тусlamж үйлчилгээг онцгойлон анхаарч, жирэмсэн эх, төрсний дараах 42 хоног доторхи төрсөн эзж болон хүнд, нэн хүнд тохиолдол бүрт Эрүүл мэндийн яамнаас томилсон зевлех багаас зайн зевлэгээг авах, тусгаарлах эмнэлгүүдэд цахим, утсаар зевлэгээ егч ажиллахыг Бусийн оношилгоо эмчилгээний төвийн дарга (Ц.Наран-Эрдэнэ)-д, жирэмсний хяналтыг сайжруулж, гэрийн эргэлтийг биечлэн болон цахимаар хийж эхийн ноцтой хүндрэл гаргахаас сэргийлж ажиллахыг Сум,Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга наарт үүрэг болгосугай.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Яаралтай гамшигийн үеийн тусlamж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн (Б.Уртнасан), Эх хүүхдийн тусlamж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн (П.Хишгээ) наарт тус тус даалгасугай.
6. Уг тушаал гарсантай холбогдуулан ЭМГ-ын даргын 2021 оны 06-р сарын 20-ны А/66, 2021 оны 07-р сарын 10-ны А/74 дүгээр тушаалуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.СҮХЭЭ

Эрүүл мэндийн газрын даргын 2021 оны  
10 дугаар сарын 07.-ны өдрийн  
10 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ  
БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

№	Чиг үүрэг	Албан тушаал	Утасны дугаар
<b>Ахлагч :</b>			
1	Б.Уртнасан	ЭМГ-ын ЯГҮҮТҮХМэргэжилтэн, эмнэлгийн тусlamж, хангалтын бүлгийн дарга	99950350
2	М.Алтанбек	БОЭТ-ийн Эмчилгээ эрхэлсэн орлогч захирал	99987877
<b>Гишүүд :</b>			
3	П.Хишгээ	ЭМГ-ын ЭХТҮҮХМэргэжилтэн	99359900
4	О.Анхбаяр	ЭЧАБЭЗХХМэргэжилтэн	94351290
5	С.Энхмаа	БОЭТ-ийн Чанарын албаны дарга	99270212
6	Ц.Саранцэцэг	БОЭТ-ийн Халдвартын тасгийн эрхлэгч	99353954
7	Б.Одонтунгалаг	БОЭТ-ийн терех тасгийн их эмч	99057151
8	С.Гүнчинсүрэн	Хувийн хэвшлийн Чандмань холбооны тэргүүн	99352335
9	С.Жаргалсайхан	Өрхийн анагаах ухааны холбооны тэргүүн	99356267
10	Ц.Дэлгэрмаа	Жаргалант сумын ЭМТэвийн дарга	99364503

Эрүүл мэндийн газрын даргын 2021 оны  
10 дугаар сарын 01.-ны өдрийн  
10 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

НАРИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨН ТУСЛАХ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

№	Овог нэр	ЭМБ-уудын нэр	Албан тушаал	Утасны дугаар	Зөвлөгөө өгөх ӨЭМТ-ҮҮДИЙН ХУВААРЬ
1	Д. Баярхүү	Бүсийн оношилгоо эмчилгээний төв	Яаралтай тусlamж эрчимт тасгийн эрхлэгч	99558893	1. Менхийн гэгээ
2	Б. Батбаяр	Бүсийн оношилгоо эмчилгээний төв	Яаралтай тусlamж эрчимт тасгийн их эмч, зөвлөх эмч	99356007	2. Энхижмандариваа
3	Л. Лхамжаргал	Бүсийн оношилгоо эмчилгээний төв	Халдвартын тасгийн их эмч	99550539	3. Нийцэл
4	Т. Соёлмаа	Эрдэнэт сувилал	Амбулаторийн Ушгины их эмч	99356669	4. Үйлбадрах
5	Л. Отгонцэцэг	Бүсийн оношилгоо эмчилгээний төв	Амбулаторийн Ушгины их эмч	99356082	5. Анхны Оч
6	Л. Ганболд	Бүсийн оношилгоо эмчилгээний төв	Төрөх тасгийн эмч, эх барих эмэгтэйчүүдийн еренхий мэргэжилтэн	99355354	6. Мэндцэцэн
7	С. Оргилбаатар	Бүсийн оношилгоо эмчилгээний төв	Хүүхдийн эмч	99934014	7. Учралтбаяр
8	Ц. Оюунцэцэг	Тайхар эмнэлэг	Мэдрэлийн эмч	99022455	8. Менхсундрэл
9	Д. Одонтуяа	Ачит эмнэлэг	Зурх судас, дотрын их эмч	99559888	9. Жаргалант сумын ЭМТөв
10	Р. Эрдэнэзаяв	Бүсийн оношилгоо эмчилгээний төв	Яаралтай тусlamж эрчимт тасгийн их эмч	99070124	10. Тусгаарлах эмнэлгүүд
11	М. Энхтуяа	Бүсийн оношилгоо эмчилгээний төв	Дотрын тасгийн эрхлэгч	99365251	

Эрүүл мэндийн газрын даргын 2021 оны  
10 дугаар сарын 28.-ны өдрийн  
11/Идугаар тушаалын гуравдугаар хавсралт

## 1. ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ БАГИЙН ЧИГ ҮҮРЭГ:

- 1.1 Коронавируст халдвартын цар тахлын нөхцөл байдалд эмнэлгийн тусламж үйлчилгээг уялдуулан зохион байгуулах, хариу арга хэмжээг шуурхай авах, Бусийн оношилгоо эмчилгээний төв, Сум, Өрхийн эрүүл мэндийн төв, тусгаарлах эмнэлгүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх баг байна
- 1.2 Баг нь сар бүр хуралдаж эмнэлгийн тусламжийн чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, тулгамдаж буй асуудлыг хэлэлцүүлэх, шийдвэр гаргуулах, шаардлагатай тохиолдолд зэлжит бус хурлыг хуралдуулж болно.
- 1.3 Аймгийн хэмжээний ногоон, шар, улаан түвшингийн Коронавируст халдвартын үеийн орны зохицуулалтыг хийж, эмнэлэг дэлгэх, татан буулгах асуудлыг шийдвэрлүүлэх
- 1.4 Баг нь Коронавируст халдвартын шалтгаант нас бараптын хамаарал, нелөөлөх хүчин зүйлд дүн шинжилгээ хийж, хариу арга хэмжээний санал, зөвлөмжийг авч хэрэгжүүлнэ.
- 1.5 Ковидын оношилгоонд хэрэглэж байгаа багаж тоног төхөөрөмж, урвалж, эм, эмнэлгийн хэрэгслийн хангарт, хүртээмжинд хяналт тавих
- 1.6 Зөвлөх баг, ӨЭМТ-үүд, тусгаарлах эмнэлгүүдийн эмч нарын хоорондын уялдаа холбоог сайжруулах, эмч, эмнэлгийн мэргэжилтнийг эмчилгээ оношилгооны чиглэлээр чадавхжуулах сургалтыг зохион байгуулах
- 1.7 Сум, өрхийн эрүүл мэндийн төвөөс батлагдсан тохиолдлыг тусгаарлах эмнэлэгт илгээх, Коронавируст халдвартын хүнд, нэн хүнд хэлбэрт шилжсэн үйлчлүүлэгчийг тусгаарлах эмнэлэг хооронд шилжүүлэх түр журмын хэрэгжилт, бэлэн байдалд хяналт тавих, хүлээгдэл чирэгдлийг бууруулахад чиглэсэн зохицуулалтыг шуурхай хийх
- 1.8 Тусгаарлах эмнэлгүүдэд хэвтэн эмчлүүлж байгаа жиремсэн эх, эмнэлзүйн хүнд хэлбэртэй үйлчлүүлэгчдэд Коронавируст халдвартын хүндрэл үүсэх эрсдэлтэй хавсарсан эмгэгтэй өвчтөний менежментийн дагуу оношилгоо, эмчилгээ тохирсон эсэхэд хяналт тавьж, мэргэжил аргазүйн зөвлөгөө өгөх
- 1.9 Эрүүл мэндийн Сайдын 2021 оны "Шинэ коронавируст халдар (КОВИД-19)-ын оношилгоо эмчилгээний шинэчлэн батлах тухай" А/549 дүгээр тушаалын хэрэгжилтэнд явцын хяналтыг хийх, зөвлөмж гаргах
- 1.10 Оношилгоо, эмчилгээнд ашиглаж байгаа шинэ эмчүүдийг судалж хэрэглэгээнд нэвтрүүлэх

## **2. НАРИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨХ БАГИЙН ЧИГҮҮРЭГ:**

- 2.1 Тусгаарлах эмнэлэг болон гэрээр эмчлэгдэж байгаа Коронавирусын халдвартай иргэдийн эрэмблэн ангилалт, оношилгоо, эмчилгээний талаар мэргэжил арга зүйн зөвлөгөөг утас, цахим, биечлэн өгөх, хамтарч үзлэг, шинжилгээ хийх, эмнэлэгт шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх зөвлөх баг байна.
- 2.2 Зөвлөх багийн эмч нар, тусгаарлах эмнэлгийн эмч нар хамтарсан үзлэгийг 7 хоног тутам хийж оношилгоо, эмчилгээнд зөвлөгөө өгөх, шаардлагатай тохиолдолд эмнэлэгт шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх
- 2.3 ΘЭМТ-үүдийн хяналтанд гэрээр эмчлэгдэж байгаа иргэдийн биеийн байдал, эмчилгээний талаарх мэдээлэлтэй танилцаж, зөвлөгөө чиглэл өгөх
- 2.4 Нэн хүнд хэлбэрийн өвчтөнг ЭМЯ-наас томилогдсон зөвлөх багтай телемедицинээр холбогдож зөвлөгөө авах, хамтран ажиллах
- 2.5 Зөвлөх багийн эмч нар яаралтай шийдвэрлүүлэх санал, асуудлыг эмнэлгийн тусламж үйлчилгээг зохицуулах багт уламжлах
- 2.6 Зөвлөгөө авах эрүүл мэндийн байгуулага болон мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх зөвлөх багийн гишүүд эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн үндсэн тулгуур зарчмыг баримтлан, харилцан хүндэтгэлтэй хандаж, хамтран ажиллана.

КОРОНАВИРУСТ ХАЛДВАРТАЙ ИРГЭНИЙГ ЭМНЭЛЭГ ХООРОНД ШИЛЖҮҮЛЭХ  
ТҮР ЖУРАМ

Энэхүү журмаар Коронавируст халдвартын хөнгөн боловч хүндрэх эрсдэлтэй, таргалалт, хавсарсан суурь эмгэгтэй, өндөр настан, дархлаажуулалтанд огт хамрагдаагүй, жирэмсэн тэрсэн зх болон эмнэлзүйн хүндэвтэр хэлбэртэй, эмчилгээнд үр дүн өгөлгүй биийн байдал хүндэрсэн өвчтөнг зэрт сэргэжлийн үнэлгээгээр үнэлэн гарцааны эмчилгээг эхлүүлж, хувийн хэвшлийн тусгаарлах эмнэлэг эсвэл Бусийн оношилгоо эмчилгээний төвд шилжүүлэн хэвтүүлэх үйл ажиллагааг зохицуулна.

1. Коронавируст халдвараар өвдсөн иргэнийг дараах журмыг дагуу шилжүүлэх:
  - 1.1 Тусгаарлах эмнэлгээс өвчтөн шилжүүлэхдээ БОЭТ-ийн орны зохицуулалт хариуцсан ажилтанд урьдчилан утсаар мэдэгдэж, уг хүний биийн байдал эмнэлэг шилжүүлэх болсон шалтгааныг танилцуулах
  - 1.2 ӨЭМТ-үүдийн гэрийн эмчилгээнд байгаа өвчтөнг эмнэлэгт илгээхдээ урьдчилан утасдаж мэдэгдэх, биийн байдал, хийгдсэн эмчилгээг танилцуулах
  - 1.3 БОЭТ-еес өвчтөн хүлээж авах бэлтгэлийг хангасны дараа өвчтөнийг эмнэлгийн эмч өөрийн биезр гарас гарт хүргэж өгөх /өвчтөнийг өөрийн биезр явуулахгүй байх/
  - 1.4 Тусгаарлах эмнэлгүүд эмнэлгээс өвчтөн илгээх хуудас АМ-13Б маягтад тухайн өвчтний онош, хийсэн эмчилгээг тодорхой бичиж, тэмдэглэж ирүүлэх
  - 1.5 Эмнэлгүүд хүчилтерөгч тээвэрлэлт хийх тоноглогдсон машингүй тохиолдолд түргэн тусламжийн машин, эмнэлэг дундын машин, бусад тээврийн хэрэгслээр тээвэрлэж хүргэх
  - 1.6 Коронавируст халдвараар өвдсөн иргэнийг анх үзсэн тусгаарлах эмнэлэг, сум. Өрхийн эрүүл мэндийн төвүүд нь цочмог өвчиний үзүүлэх тусламжийн үндсэн зарчмыг баримтлан эмчилгээг хугацаа алдалгүй эхлүүлэх, амь тэнссэн үеийн яаралтай тусламжийг үзүүлэх, Коронавируст халдвартын үеийн гарсаа эмчилгээг эхлүүлж, эмнэлэгт шилжүүлэх /хүчилтерөгчөөр дэмжих, шинж тэмдэгийн эмчилгээ, вирусын эсрэг эмчилгээ, антибиотик г.м /
  - 1.7 Эмнэлгүүд хэвтэн эмчлүүлж буй өвчтөнд ЭМС-ын "Шинэ коронавируст халдарын оношилгоо, эмчилгээний тур заавар шинэчлэн батлах тухай" А/549 дүгээр тушаалын дагуу зэрт сэргэжлийн үнэлгээ(NEWS 2) хийж, хяналтыг давтамжийн

дагуу хянаж, 7-оос доош оноотой болсон үйлчлүүлэгчийг эрчимт эмчилгээний тасагт шилжүүлэх

1.8 Эмнэлгүүд нарийн мэргэжлийн змч нарын үзлэгийг /обход/ тогтмол зохион байгуулах

**ӨЭМТ-ҮҮДИЙН ТУСГААРЛАХ ЭМНЭЛЭГТ ХЭВТҮҮЛЭХ ХУВААРЬ**

№	Тусгаарлах эмнэлгийн нэр	Орны тоо	Харьяалагдах ӨЭМТ-үүдийн нэр
1	Баян-Өндөр мед Нэгдсэн эмнэлэг	80	Анхны оч, Менхийн гэгээ, Уйлсбадрах
2	Ачит эмнэлэг	50	Анхны Оч, Нийцэл,
3	Талын булаг эмнэлэг	60	Уйлсбадрах, Энхжих Мандариеваа
4	Тайхар эмнэлэг /Эрдэнэт зочид буудал/	60	Мэндцэцэн, Нийцэл
5	Бадархундага эмнэлэг	60	Мэндцэцэн, Мөнхсүндрэл
6	Очир увидас эмнэлэг	50	Учралтбаяр, Энхжих мандариеваа
7	Эрхэст Оргил эмнэлэг / Шинэ-Эрин Мед төрөлжсөн эмнэлгийн байранд/	50	Менхийн гэгээ Мөнхсүндрэл, Учралтбаяр
8	БОЭТ, Эрдэнэт сувилал	220	8 ӨЭМТ-үүд, хувийн хэвшлийн тусгаарлах эмнэлэг, сумын ЭМТ

Буртгалийн код

--	--	--	--	--	--

РД						
----	--	--	--	--	--	--

ЭМД						
-----	--	--	--	--	--	--

### ЭМНЭЛГЭЭС ӨВЧТӨН ИЛГЭЭХ ХУУДАС

1. Эцаг /ах/-ийн нэр \_\_\_\_\_ Нэр \_\_\_\_\_ Нас \_\_\_\_\_ 2. Хүйс /зур/ эр, эм  
 Эмчилгээ сношлогоо хийлгэсэн эмнэлгийн нэр \_\_\_\_\_  
 Онош: \_\_\_\_\_

Хийгдсэн эмчилгээ:

- 1
- 2
- 3
- 4

Эмнэлгээ гарах үеийн биевийн байдал: \_\_\_\_\_

Өвчтөнд өгсөн зөвлөгөө

Эмийн эмчилгээ \_\_\_\_\_

Эмийн бус эмчилгээ \_\_\_\_\_

Хүлээн авч буй эрүүл мэндийн байгууллагад өгөх зөвлөмж:

Шилжүүлж буй эмчийн нэр Хувийн тамга:

\_\_\_\_\_ он \_\_\_\_\_ сар \_\_\_\_\_ өдөр

## ХАВСРАЛТ 1.

### ШИНЭ КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ҮЕД ХИЙГДЭХ ЭРТ СЭРЭМЖЛҮҮЛЭХ ҮНЭЛГЭЭ

Эрт сэрэмжлүүлэх үнэлгээ							
Үнэлгээ	3	2	1	0	1	2	3
Нас				<65			≥65
Амьсгалын тоо	≤8		9-11	12-20		21-24	≥25
Сатураци	≤91	92-93	94-95	≥96			
Нэмэлт хүчилтерэгч		Тийм		Үгүй			
Систолын даралт	≤90	91-100	101-110	111-219			≥220
Пульс	≤40		41-50	51-90	91-110	111-130	≥131
Ухаан санааны байдал				Укаантай			
Биенийн хэм	≤35.0		35.1-36.0	36.1-38.0	38.1-39.0	≥39.1	

- Эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа КОВИД-19 халдвартай өвчтөний биеийн байдлыг "Эрт сэрэмжлүүлэх үнэлгээ"-ний дагуу хянаж үнэлнэ.
- Эрт сэрэмжлүүлэх үнэлгээгээр ≥7 оноотой өвчтөнийг эрчимт эмчилгээний эмчийн зөвлөгөө авч эрчимт эмчилгээний тасагт шилжүүлэх арга хэмжээг авна. Эрт сэрэмжлүүлэх үнэлгээний оноо 7-оос өндөр үед 48 цагийн доторх нас баралт 50% гэж үздэг байна.

#### Эрт сэрэмжлүүлэх үнэлгээний оноо, хяналтын давтамж, авах арга хэмжээ

Оноо	Эрдээлийн үнэлгээ	Аюулын түвшин	Хяналтын давтамж	Эмнэлзүүн багийн хариу арга хэмжээ	Шийдэл
0	/		12 цаг	Тогтолц хянана	/
1-4	Бага	Шар	6 цаг	Орны дэргэдэх сувилагчийн үнэлгээ	Хяналтын давтамжийг нэмэгдүүлэх/ эмчид мэдэгдэх
5-6 эсвэл аль нэг үнэлгээ 3 байх	Дунд	Улбар шар	1-2 цаг	Орны дэргэдэх сувилагч үнэлгээг эмчид мэдэгдэх	Одоо байгаа эмчилгээг хадгалах/ эмчилгээний төвлөвлөгөөг тохируулах CCRRT* алсын зайн зөвлөгөө
≥7	Өндөр	Улсан	Үргэлжилсэн	Орны дэргэдэх сувилагч үнэлгээг эмчид хэрэвтэй мэдэгдэх	CCRRT* зөвлөгөө
≥7	Өндөр	Хар	Үргэлжилсэн	<ul style="list-style-type: none"> <li>• Хүнд вачний төгсгөлийн шат, эргэшгүй тархины гэмтэл, олон эрхтний дутагдал, архаг элэг, уушгини өвчин төгсгөлийн шат, үсэрхийлсэн хавдар гэх мэт.</li> <li>• Мэргжилтнүүд эрдээлт бүлгийнхний тухай яаралтай шийдэх</li> </ul>	

### Эрг сэрээнхүүхүүк хүэлгээний оноо, хяналтын давтамж, авах арга хэмжээ

Оноо	Эрсдлийн үнэлгээ	Аюулын түвшин	Хяналтын давтамж	Эмнэлгүүн багийн хариу арга хэмжээ	Шийдэл
0	/	-	12	Тогтолцоулсан хяналтын давтамжийг нэмэгдүүлэх,	
1-4	Бага	Шар	6 цаг	Орны дэргэдэх сувилгачийн үнэлгээ	Хяналтын давтамжийг нэмэгдүүлэх, эмчилгээний төлөвлөгөөг тухайн нэхцэгдүүг хадгалах, хамтарсан үзлэг хийх, алсын зайн зөвлөгөө авах
5-6 эсвэл аль нэг үнэлгээ 3 байх		Дунд	Улбар шар	Орны дэргэдэх сувилгачийн үнэлгээ эмчид мэдэгдэх	Одоо байгаа эмчилгээг хадгалах, нэхцэгдүүг хадгалах хамтарсан үзлэг хийх, алсын зайн зөвлөгөө авах
≥7-8	(Энээр нэг үнэлгээ байх)	Уланан	Ургамжийн үнэлгээ	Орны дэргэдэх сувилгачийн үнэлгээ	Алсын зайн зөвлөгөө авах
≥7-8		Хар	Үргамжилсан хархийн хавдар гэх мэт	Хүндийн тогтолцоулсан шат эргашгүй гаржмын шат эргашгүй гаржмын гэмтэл олон архтэндүү дугаалай архдаг ушгийн өвчиний төгсгөлийн шат усархийнцэн хавдар гэх мэт	

Ашигласан материал:

1. "Шинэ коронавируст халдвар (КОВИД-19)-ын оношилгоо, эмчилгээний тур заавар шинэчлэн баглах тухай" ЭМС-ЫН 2021 оны 7 дугаар сарын 8-ны А/467 дугаар тушаал
2. "2020-2021 оны томооѓийн улиралд баримтлах эмнэлгэйн удирдамж" ЭХЭМУТ, 2020 он, 52х
3. <https://www.ndcaic.com/pediatric-early-warning-score-pews>
4. <https://www.tamesidehospital.nhs.uk/documents/paediatricearlywarningsscoringspolicy.pdf>
5. <http://generalpracticemedicine.org/PEWS/SheetApril2017Final2.pdf>
6. <https://www.childrensmn.org/departments/webm/pdf/pews-pre-learning-module.pdf>
7. [https://en.wikipedia.org/wiki/Pediatric\\_Early\\_Warning\\_Signs](https://en.wikipedia.org/wiki/Pediatric_Early_Warning_Signs)
8. <https://www.hse.ie/eng/services/publications/clinical-strategy-and-programmes/pews-user-manual.pdf>
9. <https://www.hse.ie/eng/services/publications/pews-user-manual.pdf>

Хүснэгт 1

ШИНЭ КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ҮЕД ХҮХДЭД ХИЙГДЭХ ЭРТ СЭРЭМЖЛҮҮЛЭХ ҮНЭЛГЭЭ

Pediatric Early Warning Score (PEWS)

Нас	Чацал	Pediatric Early Warning Score (PEWS)				3	
		3	2	1	0		
0-4 сар хүртэл	Пульс/минут	<80	80-89	90 - 109	110 - 159	160 - 175	176-189 >190
	Амьсгалын тоо/минут	<20	-	20 - 29	30 - 55	56 - 60	>60
	Биений хэм (°C)	-	<36	36,0 - 36,4°	36,5 - 37,5°	37,6 - 38,5°	>38,5
	Систолын даралт (ттмHg)	-	-	-	60 - 80	-	-
4 сараас 2 нас хүртэл	Пульс/минут	<80	80-89	90 - 99	100 - 149	150 - 159	160-169 >170
	Амьсгалын тоо/минут	<15	-	15 - 24	25 - 34	35-44	>55
	Биений хэм (°C)	-	<36	36 - 36,4°	36,5 - 37,5°	37,5 - 38,5°	>38,5
	Систолын даралт	<45	45-49	50 - 59	60 - 80	81 - 100	>130
2-5 нас хүртэл	Пульс/минут	<60	-	60 - 79	80 - 119	120 - 129	130-139 >140
	Амьсгалын тоо/минут	<10	-	10 - 19	20 - 29	30 - 39	>50
	Биений хэм (°C)	-	<36	36 - 36,4°	36,5-37,5°	37,5 - 38,5°	>38,5
	Систолын даралт	-	-	-	90-129	-	-
5-12 нас хүртэл	Пульс/минут	<60	-	60 - 69	70-119	120 - 129	130-139 >140
	Амьсгалын тоо/минут	<10	-	10 - 19	20 - 29	30-39	>50
	Биений хэм (°C)	<35	-	35 - 35,9	36-37,9°	38,0 - 40°	40°+ -
	Систолын даралт	-	-	-	90 - 129	-	-
12-	Пульс/минут	<60	-	60 - 69	70-99	100 - 109	110-119 >120

наснаас дээш	Амьсталын тоо/минут Биений хэм (°C) Систолын даралт	<10 ≤35 >70	10-15 35.1 - 36 80-89	15 - 24 36.1-38 90 - 129	25-34 38.1 - 39 -	35-44 ≥39 -	245 ->220
Ухаан санааны байдал (AVPU)	Чимээнд хариу өгөх хариу супрах	Ярглах (Grunting) Амьсгал авалт, гаралтанд хэржигнуур зайнаас сонсодгох бүх насанд	Амьсгал гаралтын турш хэржигнуур зайнаас сонсодгох амьсгал зогсолт	Орчны харьцаа супрах	Орчны харьцаа супрах	Тайван бус цочромтой Цээж дунд зэрэг хонхолзох (Severe) Өвчүү болон өвчүүний дээд хэсэг эсвэл яраглах (Grunting) амьсгал зогсолт	Ухвангуй, өвдөлтэнд хариу супрах Цээж хүчтэй хонхолзох (Severe) Өвчүү болон өвчүүний дээд хэсэг эсвэл яраглах (Grunting) амьсгал зогсолт
Хүүдийн бүх насанд	Амьсгал	Чанхад амьсгал гаралтын төгсгөлд хэржигнуур сонсодгох	Хэвийн (эмзэг шүүгиангуй)	Цээж бага зэрэг татагдах (Mild) Хавиргын доод болон бүчүүний доод хэсэг	Хэвийн (эмзэг шүүгиангуй)	Хавиргын доод болон бүчүүний доод хэсэг	Хавирга (Moderate) Хороонд болон этгэний дээд хэсэг
Сатураци Нэмэлт хүчинчлөрөн	FIO2-50%, 5+ L/min	<91% FIO2-40%, 4+L/min	91-94% FIO2-30%, 2-3+ L/min	295% Өрөөний агаар Хэвийн (ягаан)	1-2сек	З3ек	4сек 2бсек
Арьсны өнгө Хялгасан судасны цус	-	-	-	цайвар	саарал	саарал	саарал
Дүүрэлт							

Хэрэв утлага, соруулга хэрэглэж буй, эсвэл хагалгааны дараах үед байнгын бөөлжилтэй бол 2 оноо нэмэгдэнэ.

- КОВИД-19 халдвартын үед эмч, эмнэлгийн мэргэжилтэн өвчтөний биенийн байдлыг "Эрт сэрэмжлүүлэх үнэлгээ"-НИЙ дагуу хянаж, үнэлэн, арга хэмжээг авна.
- Эрт сэрэмжлүүлэх үнэлгээний өвчтөнийг эрчимт эмчилгээний эмчийн зөвлөө авч, Эрчимт эмчилгээний тасалт шилжүүлэх арга хэмжээ авна.
- Эрт сэрэмжлүүлэх үнэлгээний ондоо 7-8-аас өндөр үед 48 цагийн доторх нас барагт 50% гэж үздэг.